

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-4

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 5-19

-
- 1. Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 5-9*
- 2. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ 9-13*
- 3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/ 13-19*

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Болорчулуун;
Чөлөөтэй: Ц.Анандбазар, Б.Бейсен, Г.Дамдинням, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл,
Ц.Цэрэнпунцаг.

Нэг.Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 17 гишүүн 2024.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнхнасан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэний дагуу санал хураалт явуулав.

Ж.Батжаргал: 1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “8.1 дүгээр зүйлийн 12.12,” гэснийг “8.1 дүгээр зүйлийн 12.12-т заасан тусгай зөвшөөрөл” гэж өөрчилж, 17.2, 17.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.5 дахь хэсгийн “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох болон экспортлох” гэснийг хасах:

“17.2.Үйлдвэрлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:”

“17.3.Импортлох зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн саналыг Байнгын хорооны дарга Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ц.Туваан нарын тавьсан асуултад Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Байнгын хорооны дарга Ж.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ж.Батжаргал хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны дарга Ж.Батжаргал “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг Засгийн газрын гишүүн байхгүй байгааг мэдэгдэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5-д заасны дагуу уг асуудлыг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 50 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 10 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 12 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өглөөний амар амгаланг айлтгая Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөө аж ахуйн Байнгын хорооны 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанд Жигжидийн Батжаргал, Жадамбын Бат-Эрдэнэ, Батсүхийн Саранчимэг, Гочоогийн Ганболд, Наянтайн Ганибал, Цагаанхүүгийн Идэрбат, Нанзадын Наранбаатар, Ганзоригийн Тэмүүлэн, Цэвэгдоржийн Туваан, Төмөртоогоогийн Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирж одоогийн байдлаар 52.6 хувийн ирцтэй байх тул өнөөдрийн хуралдааныг албан ёсоор эхлүүлж байна.

Өнөөдрийн хуралдаанаар Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг.

Хоёрт нь Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлэг.

Гуравт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг. Энэ Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулж 1 заалттай ийм хуульд өөрчлөлт орж ирж байгаа юм.

Дөрөв. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллын

өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2024 оны 6 дугаар сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. Ийм 4 асуудал хэлэлцэхээр тусгагдсан байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт, саналтай гишүүд бий юү?

Алга байна.

Хэлэлцэх асуудлаа баталлаа. Хэлэлцэх асуудалдаа орё.

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн нарын 17 гишүүнээс 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 42.1.1-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг танилцуулах гэсний дагуу чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэг бүрчлэн тусгаж эцсийн хувилбарын төслийг бэлтгэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Малчны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарын төслийг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ажлын хэсэг Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Цэвэгмэдийн Мөнхнасан мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Мал аж ахуйн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн.

Асуулттай гишүүн бий юу?

Туваан, Ганибал гишүүнээр тасаллаа. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Энэ Малчны тухай гээд хуулийн төсөл орж ирж байгаа. Энэ хуулийг дэмжиж байгаа. Яагаад гэхлээр Монгол Улсын эдийн засагт маш чухал байр суурийг эзэлдэг хөдөө аж ахуйн салбар. Тэр дундаа ачааны 80, 85 хувийг үүрч яваа малчдын амьдралтай, орлоготой, нийгмийн хамгаалалттай холбоотой асуудлууд энэ хууль дотор орж ирж байгаа учраас дэмжиж байгаа юм.

Ер нь сүүлийн чуулганы 2024 оны чуулган хаах тийшээгээ болчихсон байна. Тэгэхээр яг энэ үед бас жоохон энэ хууль оройтоод ороод ирж байгаа юм уу даа гэж ингэж бодож байгаа. Бас хуульд сүүлийн үед бид нар энэ мал аж ахуйтай холбоотой энэ Уур амьсгалын өөрчлөлтөөс гээд нэг хууль, тэр нь ер нь зудын эрсдэлийг арилгах тухай хууль байгаа. Тэр дотроо энэ хоршооны асуудлыг оруулаад ирчихсэн. Дээрээс нь энэ Малчны тухай хууль, бас мөн Үйлдвэржилтийн байнгын хороон дээр малын гаралтай түүхий эдийн гээд тэгээд энэ мал аж ахуйтай холбоотой асуудлууд бас жоохон оройтоод яг энэ

чуулган хаахтай зэрэгцээд орчхов уу даа гэж ингэж бодож байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг ер нь яг тухайн үед нь цаг хугацаанд нь ингэж ярих байсан юм бол гэж ингэж бодож байгаа. Энэ хууль дотор энэ малчдын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр яг манай мал аж ахуй өнөөдөр байгалийн гамшигийн өмнө бас өрсөлдөх чадвартай байна уу, үгүй юү гэдгийг бас ярих хэрэгтэй болж байгаа юм.

Саяхан бас би нөгөө тайлангаа тавиад Төв аймгийн, Дархан-Уул аймгийн, Сэлэнгэ аймгийнхаа нутгаар явсан. Тэгэхэд энэ манай малчид нөгөө малчны зээл тэглэх асуудал, малжуулах төсөл хэрэгжүүлэх асуудлыг л нэлээн ярьж байна. Саяхан энэ Малчдын нэгдсэн холбоо гээд холбооны хүмүүс 100-аад мянган хүний гарын үсэг зурчихсан энэ ордны үүдэнд ирнэ лээ. Гарч уулзсан. Засгийн газрынхан энэ асуудлыг хүлээж авсан байх.

Тэгэхээр энэ хоршооны асуудлыг бол яах вэ тэр зээл хоршооны мөнгө төгрөг өгвөл тэрийг нь авдаг юм байгаа биз. Яах вэ нэг зүйл ойлгомжгүй байгаа нь өөрсдийнхөө малыг барьцаалж зээл авчхаад тэр мөнгөө өөрсдөө захиран зарцуулах эрхгүй байгаа гэдэг л асуудал харагдаад байгаа юм. Эргээд тэр зээлээ малчин өөрөө бага хувийн хүүтэй ч гэсэн тэр зээл өөрөө төлөх учраас нэлээн асуудал байгаа юм. Ингээд би зөвхөн 1 сумын малчдын 24 малчин тухайлах юм бол, Төв аймгийн Баян сумын Шаравсамбуугийн Одхүү, Дамдинсүрэнгийн Ганбаатар, Батбаатар, Санжаажамц, Пүрэв, Одбаяр гээд ийм улсууд ингээд надыг очихоор өргөдөл өгч байгаа юм. Ямар өргөдөл вэ гэхээр нөгөө малчны зээл тэглэх асуудал чинь юу болов? Жишээлэх юм бол энэ дээр Шаравсамбуугийн Одхүү гэдэг хүн малынхаа 77 хувийг хорогдуулсан. Энэ хаврын зуд зүгээр

жирийн болдог зуд биш. Энэ бол байгалийн гамшиг, төмөр, шилэн зуд болсон.

Тэгэхээр энэ асуудлаа энэ Малчны тухай хууль энэ тэр дээр чинь яаж тусаж байгаа юм бэ? Бид нар энэ байгалийн эрсдэлийн өмнө дахиад ийм нөхцөл байдалд орвол энэ асуудал энэ хуульд яаж туссаныг бүр асууж өгөөч гээд. Ингээд надад бүр малчдынхаа нэрсийн цувааг, өргөдлүүдтэйгээ ингээд өгсөн. Энэ бол зөвхөн 1 сумын жишээ болчхож байгаа юм. Тэгэхээр энэ асуудал дээр бас хууль санаачлагчаас энэ дээр хариулт өгөөч.

Дээрээс нь энэ малжуулах хөтөлбөр маань юу болчихоо вэ? Нөгөө Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүрээнд байна уу, эс үгүй бол энийг нь нэмэх боломж байна уу? Энэ 2 дээр хуультай холбогдуулаад хаана орсон?

Ж.Батжаргал: Тийм, энэ бол эцсийн хэлэлцүүлэг. Тийм учраас юу байхгүй. Яг энэ дээр хариулт өгөх юу байхгүй. Төсөл өргөн баригчийн хувьд яг энэ асуудал дээр товчхон юу өгчих. Хэдүүлээ ойлголтоо нэг байлгахын хүрээнд Тэмүүлэн гишүүн тайлбар өгөөдөх дөө.

Г.Тэмүүлэн: Туваан гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ Малчны тухай хууль маань бол өнөөдөр ингээд эцэслэн батлагдах гэж байна. Тэгэхээр энэ хуулийн төслийг бол бид нар яах вэ цаг хугацааны хувьд бас нэлээн оройтож байгаа ч гэсэн ялт ч үгүй л 1, 2 жил гаруй хугацаанд ажиллаж байгаад боловсруулаад ингээд гаргаж ирсэн хууль учраас ямар ч бай энэ удаагийн парламент маань бол амжаад энэ хуулийг бол бас гаргаж ирж байна. Энэ хууль дээр гол анхаарах бас яг таны сая асуусан асуулт энэ байгалийн гамшигтай холбоотой асуудлууд байгаад байгаа.

Тэгэхээр байгалийн гамшиг үндсэндээ нөгөө хэлж ирдэггүй, хийсээж ирдэг асуудлууд. Бид нар энд ямар байдлаар бас бэлэн байх ёстой. Төр засаг нь бас анхаардаг байх ёстой. Энэ үндсэн дээр нэг зүйлийг бол оруулж өгсөн нь хэрэв юу гэдэг юм нөгөө байгалийн гамшигт тухайн малчны мал сүрэг нь өртөх юм бол, эсвэл аюулт үзэгдэлд нийт мал сүргийнх нь 50-аас доошгүй хувь нь өртөх юм бол бид нар бол тухайн тэр малчныг бол малжуулах хөтөлбөрт хамруулах гэдэг зохицуулалтыг бол хийж өгсөн байгаад байгаа.

Зөвхөн малжуулах хөтөлбөр дээр бол бас нэг талдаа хуульчилж оруулж өгч байгаа. Анх удаагаа хуульчилж байгаа зүйл маань бол нэгдүгээрт гамшигт өртсөн, мөн дээрээс нь 16-40 хүртэлх насны залуу малчид, мөн дээрээс нь юу гэдэг юм шилжин суурьшиж байгаа малчид ч гэдэг юм уу энэ зохицуулалтыг бол бас анх хуульчилж оруулж өгч байгаа. Саяын тэр ер нь малжуулах хөтөлбөртэй холбоотойгоор бид нар бас зохицуулалтыг оруулж өгсөн зүйл маань бол ерөөсөө малчны хөгжлийн зээл гэдэг зүйлийг энэ хууль дээрээс гаргаж өгч байгаа.

Тэгэхээр нөгөө малжуулах төсөл маань бол хуучин сум сумын онцлогоос хамаараад сум хөгжүүлэх сангаасаа өөр өөрсдийнхөө тус үзэмжээр хэрэгжүүлдэг байсан. Тусгай шалгуур шаардлагыг нь бол тухайн сум орон нутаг өөрсдөө тогтоодог байсан бол одоо бид нар энд малжуулах хөтөлбөрийг бол малчны хөгжлийн зээл гэж оруулж өгөөд нэн хөнгөлөлттэй зээл гэдэг зүйл дээр малжуулах хөтөлбөрийг бол оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр бол цаашидаа Засгийн газар журмыг нь гаргаад зохицуулалтыг хийгээд явна. Ингэснээрээ тухайн тэр малжуулах хөтөлбөр маань бол нэн хөнгөлөлттэй зээл гэдэг үүднээс бол одоогоор төсөөлж харж байгаагаар бол хүүгүйгээс магадгүй нэн хөнгөлөлттэй буюу 0-44 хувийн нэг хугацаа хугацаатай

зээл бол байх зайлиггүй шаардлагатай байгаад байгаа юм.

Тэгэхээр нөгөө мал гамшигт өртсөн нөгөө малчин маань бол малжуулах хөтөлбөрийнхөө үндсэн зээлийг буцаад төлөх энэ зохицуулалт маань бол тодорхой хугацааны дараа бол хийгдэх зайлиггүй шаардлагатай бол байгаад байгаа юм.

Ж.Батжаргал: Ганибал гишүүний микрофоныг өгье.

Н.Ганибал: Малчны тухай хууль. Ер нь энэ хууль чинь орж ирээд яасан ч их өөрчлөлт орчхов доо тийм ээ? Ер нь энэ хууль дээр нэг тал маш сайн орсон байна. Мэдээж үйлдвэрлэгч тал дээр түүхий эдийг бид нар яаж юу бэлтгэх вэ, ямар стандарт шаардлагын дагуу бэлэн байх юм тэрийг үйлдвэр авах уу гээд ингээд энэ нэг тал бол аягүй сайн орсон.

Нөгөө талаа бид нар дандаа орхиод байна. Энэ өөрөө юу вэ гэхээрээ малчнаас гарч байгаа түүхий эдийн үнийг чөлөөлөхгүй бол өнөөдрийн барьж байгаа бодлогоо бид нар цааш нь явуулах юм бол бид нар мянган гоё хууль хийгээд энэ хуулиуд хэрэгжихгүй. Нэгд хэрэгжихгүй.

Хоёрт, өнөөдөр малчид маань энэ орлого нь нэмэгдэхгүй бол бид нар хоршооны хууль гээд хийлээ. Одоо малчдын холбоо гээд төр бүүр холбоо байгуулдаг хууль хийлээ. Хоршоогоор дамжуулаад хөнгөлөлттэй зээл олгоно гээд явуулж байна. Тэгээд энэ болгон өнөөдөр бид нарын бодож байгаа малчдын амьдралыг сайжруулах гарц биш, гарц биш. Зүгээр бодит үнэнийг хэлье. Яг бид нар энэ хууль дээр уг нь нэг орсон заалт байна лээ, байгаа л даа. Уг нь малчдын түүхий эдийг зах зээлийнх нь үнээр нь явуулъя. Зах зээлийнх нь үнээр явуулахгүй бол төр өөрөө урамшууллын системээ ашиглаад явуулъя гэсэн ийм нэг заалт байсан.

Тэгээд нөгөө зах зээлийн зарчмаар явуулна гэдэг заалт нь байхгүй болчихсон. Өнөөдөр Үйлдвэржилтийн байнга байнгын хороон дээр манай малчдын эсрэг ч юм шиг тийм тэр Цагаан алт гээд хөтөлбөр хэрэгжих гээд явж байх шиг байна. Би нарийн сайн судлаагүй байна. Манай Байнгын хороогоор орж ирээгүй учраас. Сая Үйлдвэржилтийн байнгын хороон дээр гаргасан тэр ноолуурыг угаагаад, самнаад гаргана гэдэг техникийн зохицуулалтын өөрчлөлтөөс болоод баруун аймгууд дээрх ноолуурын үнэ унасан. Унасан.

Яах вэ та хэд зүгээр сонсчих. Ер нь аливаа юманд үйлдвэрлэлээ хөгжүүлэх бодлого, малчдын түүхий эдийг бараагаа бүтээгдэхүүнээ зарах бодлого хоёр хоорондоо харшилдах зүйлүүд байгаа. Энэ өөрөө зах зээлийн зарчим. Энэ зарчмаас яагаад тэгвэл энэ 7 сарын 1-нд байсан техникийн зохицуулалтыг хойшлуулсан юм? Шалтгаантай учраас л хойшлуулж байгаа байхгүй юу.

Яагаад гэхээрээ үндэсний үйлдвэрлэлүүд ноолуураа худалдаж авах тэр бэлэн мөнгөгүй болонгуут тэн дээр ноолуурын үнэ буучихсан байхгүй юу. Тэгэхээр бид нар өнөөдөр бид нар Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, сонсож бай, зүгээр сонсож бай Ганболд гишүүнээ. Яагаад гэдэг үгийнхээ хариултуудыг та нар өөрсдөө Засгийн газар чинь тэр тогтоолоо хойшлуулчихсан шүү дээ. Шалтгаан байгаа шүү дээ. Бямбацогтын тэр фэйсбүүк дээр тэр санаачилга гаргаад энийг хойшлуулъя гээд энэний дагуу хойшлуулчихсан шүү дээ. Тэгээд нэг нь юм яриад, нөгөөдөх нь тэрийг засах гэж. Энэ улс төржиж байгаа асуудал биш шүү. Зүгээр энэ чинь өөрөө онолын асуудал байхгүй юу даа. Тэрнээс биш хэн нэгнийг муулах гээгүй. Тэгэхээр бид нарын гаргаж байгаа хууль малчдынхаа эрх ашгийг хамгаалсан байгаасай л гэж хүсээд байгаа юм. Оруулж ирсэн заалтуудыг чинь бүгдийг нь байхгүй болгоод оронд нь Тэмүүлэн гишүүнээ,

оронд нь дандаа малчдад хариуцлагын асуудлуудыг л түлхүү оруулчихсан байна шүү дээ. Угаасаа л байгаа л асуудлууд биз дээ?

Өнөөдөр бид нар бүгдээрээ мэдэж байгаа арьс ширний асуудал дээр адууны шир үнэ цэнгүй болгож байгаа асуудал бол өөрөө тэр техникийн зохицуулалтын асуудал байхгүй юу. Бүгдээрээ мэдэж байгаа тэрийгээ цуцалсан. Харамсалтай нь бид нар зах зээлээ алдчихсан. Одоо бид нар ноолуур дээр бас болгоомжтойгоор Монголын үндэсний үйлдвэрлэлүүдийн хүчин чадлууд сайжирсан. Тэр үед л энэ арга хэмжээнүүдийг цэгцтэй бодлоготой авахгүй бол сая эргээд ноолуур дээр тэр нөхцөл байдал чинь давтагдаад байгаа байхгүй юу даа. Энэ өөрөө бодитой. Та хэд маань энийг, би хэн нэгэн рүү дайрах гэж хэлээгүй юм. Тэгэхээр бид нар энэ Малчны тухай хуулийн ер нь үндсэн гол концепцууд маань бас жоохон гээгдчихсэн байна л гэж би хэлэх гээд байгаа байхгүй юу.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Малчны тухай хууль бол угаасаа малчдынхаа эрх зүйн байдлыг тодорхойлж байгаа эрх, үүргийнх нь асуудал. Энэ малчдынхаа нийгмийн баталгааны тухай асуудлыг зохицуулсан ийм л хууль болж орж ирж байгаа гэдгийг хэлье. Нэг.

Хоёрдугаарт, ерөөсөө энэ тусгаар Монгол Улс байгаа юм бол энэ дотоодынхоо хэрэглээ юмнуудыг өөрсдөөсөө хангадаг юм руугаа явахгүй бол хэрэглэгч байж хэрэглэгч улс орон болоод дандаа бүх юмаа гаднаас авчирдаг байж таарахгүй. Өөрийнхөө нөөц дээр тулгуурлаж боловсруулалтынхаа түвшнийг ахиулдаг байх ёстой биз дээ. Ийм балай юм ярьцаахаа боль. Ноолуурын боловсруулалтын түвшнийг ахиулахаар үнэ цэн л ордог болохоос биш хэзээ байхдаа үнэ нь унадаг юм. Ямар юман дээр тулгуурлаж ийм юм ярьцаагаад байгаа юм бэ энэ чинь. Тийм байж болохгүй.

Малчны тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлгийн Байнгын хороогоор хийсэн танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг танилцуулъя. Дараагийн асуудалдаа оръё.

09.38 цаг

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг гишүүд та бүхэнд хүргүүлсэн.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Түрүүний асуудал дээр өөрчлөгдсөн юм байна тээ. Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Бямбын Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтны эрүүл мэндийн газрын дарга, Сандагийн Батхуяг Мал эмнэлгийн ерөнхий газрын Статистик, дүн шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн. Би гаргах юм уу энийг? Тийм байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдааны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль

орчин, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3 дахь хэсгийг гүйцээн боловсруулж, 1 зарчмын зөрүүтэй саналыг боловсрууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэн та бүхэндээ хүргүүлсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье.

Танилцуулгатай холбогдуулж асуух зүйл бий юу?

Ганибал гишүүнээр тасаллаа. Туваан гишүүний микрофоныг өгье.

Ц.Туваан: Энэ малын эмч нар ярьдаг юм. Хүний эмч бол хүний л эмч. Малын эмч бол ертөнцийн эмч гээд. Тэр нь ямар учиртай гэхээр нөгөө хүний хоол хүнсэндээ хэрэглээд өдөр болгон хэрэглэдэг хүнсний эрүүл мэндтэй холбоотой асуудлыг ярьдаг юм. Тэгэхээр энэ асуудал дээр энэ хууль маш чухал асуудал л даа.

Өөрөөр хэлбэл, Мал, амьтны эм орж байгаа, тэгээд тэжээлийн

нэмэлтийн асуудал орж байгаа. Юу ярих гээд байна гэхлээр бид бүхэн энэ дээр, энэ хууль дотор энэ бүгдээрээ зөвшөөрөл бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт гээд юмнууд байгаа. Энэ дотор энэ хяналтын асуудлыг нь яаж нарийвчилж оруулсан бэ? Малын эмийн үлдэгдэл гэж юм маш чухал болчихоод байгаа.

Юу хэлж байна гэхлээр энэ Монгол Улс өнөөдөр маш олон төрлийн хавдраараа дэлхийд тэргүүлж байгаа. Энэ ямар учиртай гэхээр энэ юунд холбоотой хүнсэнд байгаа, би Ганболд гуай би үгээ хэлж байна шүү. Үг өгчихсөн. Үгээ хэлж, асуултаа асууж байна. Яах гээд байгаа юм бэ? Үгүй тэгээд асууж болдоггүй юм уу? Асуу гээд микрофон нээхээд байна. Байж бай миний минутыг битгий хаагаад бай. Энэ хүнсний ялангуяа энэ маханд үлдэж байгаа эмийн үлдэгдлийн хяналтыг ямар лаборатори яаж орсон юм?

Өөрөөр хэлбэл, хүнсэнд үлдэж байгаа антибиотикийн үлдэгдлийн асуудлыг л яриад байгаа юм би. Энэ эм малын эвомекоос өгсүүлээд, цагаан тарианаас өгсүүлээд энэ эмүүдийн хэрэглээ ерөөсөө замаа алдчихлаа. Юу гэхлээр ямар нэгэн хяналтгүй, зохицуулалтгүй, дур дураараа тарьдаг ийм асуудал нэлээн газар авчхаж байгаа юм.

Тэгэхээр энэ эмийн үлдэгдлийг антибиотикийн үлдэгдлийг нарийн үзэхгүйгээс болоод бид нар дөнгөж антибиотик эвоmek тарьсан малын мах хүнсэнд нийлүүлэгдээд энийг хүн амаараа хоол байдлаар идээд ингээд энэ хавдрын өвчлөлийн нэмэгдэлт ихсээд байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг энэ хууль дээрээ энэ Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль дээрээ яаж тусгасан юм болоо гэдэг нэг асуулт байгаа юм. Бид бүхэн сая.../үг тасрав./

Ж.Батжаргал: Туваан гишүүн ээ. Тийм наад ажлын хэсгийнхээ санал,

дүгнэлттэй холбогдуулж асууж тодруулах юм.

Ц.Туваан: Одоохон дууслаа. Үгүй үгүй харин тийм.../үг тасрав./

Ж.Батжаргал: Наадах чинь анхны хэлэлцүүлэг дээр яригдах байхгүй юу.

Ц.Туваан: Үгүй үгүй тэгэхдээ харин боломж олдсон, асуултаа дуусгачихъя.

Ж.Батжаргал: Эцсийн хэлэлцүүлэг явж байна. Юуг нь тасалъя. Энэ дэг зөрчигдөөд болж өгөхгүй байна. Ганибал гишүүн. Таныг би зөвхөн энэ гүйцээн боловсруулах.../үг тасрав./

Н.Ганибал: Батжаргал даргаа, Батжаргал даргаа, хөөе Батжаргал дарга та ингээд бусдыгаа хүндэл л дээ. Зөвхөн микрофон бариад, алх барьсан хүмүүс нь бүгдийгээ.../үг тасрав./

Ж.Батжаргал: Та харин, та нар харин дэгээ барьчхаач дээ. Угаасаа хэчнээн жил энэ Их Хуралд суугаад хэдүүлээ дэгээрээ явдгаа мэддэг биз дээ?

Н.Ганибал: Тэгээд тодруулаад энэ чинь ингээд эрхийг нь л өгчих л дөө. Яачихсан гээд байгаа юм энэ чинь, юу нь болохгүй байгаа юм? Энийг хэлээд

Ж.Батжаргал: Үгүй үгүй харин эцсийн хэлэлцүүлэг яаж орж ирдэг билээ дээ. Дэгээрээ л яваач дээ энэ чинь.

Н.Ганибал: Юу нь муухай болчих гээд байгаа юм? Энэ чинь юу нь муухай болчих гээд байгаа юм? Энэ чинь санаа зовоод л асуулт асууж, ярьж байна шүү дээ.

Ж.Батжаргал: Үгүй энэ гүйцээн боловсруулах асуудал дээрээ л юмаа ярина шүү дээ.

Н.Ганибал: Би энэ минутаа аваад бодлогоо юугаа яриадахъя. Саналаа хэлээдэхье болно биз дээ?

Ж.Батжаргал: Үгүй энэ гүйцээн боловсруулах дээрээ л юмаа ярь.

Н.Ганибал: Одоо энэ, за алив эргээд минутаа аваад энэ хэрүүлийн асуудлаа больё. Шинээр минутаа авмаар байна шүү дээ. Яришиг ингээд ярьчихъя даа.

Үгүй бид нар ийм байхгүй юу даа. Бид нар энэ асуудлуудыг ер нь зүгээр эцэслэн батлах гэж байгаа энэ цаг үед нь бас ер нь зөв юм уу, буруу юм уу гээд яриад байна шүү дээ. Энэ чинь бид нарын саналаа хэлэх үүрэгтэй юм байгаа биз дээ? Эрхийн асуудал биз дээ энэ? Юу яриад байдаг юм анхны хэлэлцүүлэг гээд? Энэ чинь эцсийн мөч хүртэл батлах гээд бид хэд явж байгаа биз дээ? Та хэд чинь нэг хүч түрээд ер нь та нар ер нь, өө энэ үгүй би ярья л даа ёё яачихсан юм бэ? Энэ чинь сонгууль арай болоогүй байна шүү дээ. Энэ 3, 4 хоногийн дараа эхлэх гээд байхад чинь энэ. Би энэ мал, амьтны энэ эмийн худалдан авалтын асуудал, ер нь түрүүн бас Туваан гишүүн ярьж байна л даа мал эрүүл бол хүнс эрүүл. Хүнс эрүүл бол хүн эрүүл. Бид нар энэнийхээ дагуу энэ ажлыг хийж байгаа гэж бодож байгаад бол энэ эндүүрэл болчихоод байгаа юм. Би энийг бас эсэргүүцээд байгаа байхгүй юу. Эцсийн хэлэлцүүлэг дээр би бас эсэргүүцнэ.

Яагаад гэхээрээ Монгол Улс өнөөдөр энэ худалдан авалтын хуулийг олон удаагийн өөрчлөлтөөр маш их буруу зам руу авч яваад байгаа юм. Одоо бид нар энэ хууль 2020 оны онд өөрчлөгдсөн байхгүй юу. Юу гэж орж ирсэн бэ гэхээрээ энэ хууль дээр үйлдвэрлэгч худалдаж авна гэдэг заалт нь, хөөе үгүй тэгээд байж бай л даа би ярьж байна шүү дээ. Энэ заалт дээрээ би хэлж байна шүү дээ. Тэгээд яагаад байгаа юм бэ? Хүүе ямар сонин юм бэ? Боль гээд байгаа юм уу? Уурлаад байх юм. Үгүй харин тийм энэ би бүр гайхаад байх юм. Энэ

хөөш өмнө нь байсан Засгийн газар шууд худалдан авалт хийснээс болоод олон хүн өнөөдөр АТГ дээр шалгагдаж байгаа шүү. Тэр асуудал цэгцлэгдээгүй, дуусгагдаагүй байгаа. Хуучин олон нийтэд нээлттэй тендер байсан, олон улсын тендер байсан. Тэрийг өөрчилснөөс болоод, шууд худалдан авалт хийснээс болоод төрийн олон албан хаагч нар өнөөдөр Авлигатай тэмцэх газар шалгуулаад мөрдөгдөөд явж байгаа. Энийгээ тэгсэн чинь засаж залруулах биш улам нарийсгаад шууд үйлдвэрлэгч худалдаж авна гэсэн заалт оруулаад манай энэ яамныхан явж байх юм. Энэ чинь бид нар олон улсын тэр стандарт шаардлага нь бол тендерийнхээ хуулийг улам сайжруулж, илүү их нээлттэй ийм болгож байж өнөөдрийн энэ авлигал багасдаг, олон худалдан авагч нарын тэр эрх ашиг ордог ийм л асуудал.

Тэгээд бид нар эсрэгээр нь ингээд яваад. Энэ чинь нөгөө ийм коммунист л арга барил руу л бид нар яваад байна шүү дээ. Ингээд та хэд чинь бас яг намтайгаа адилхан болох гээд, одоо юу гэж хэлэх юм бэ. Би зарим нэг юман дээр та нар дуугарч байя л даа. Юмаа эсэргүүцэж бай, хэлж бай. Ингэж байж бид нар чинь энэ хуулиудаа зөв болгох байхгүй юу. Би та бүхэнд хэлчихье. Шууд худалдан авалтын энэ олон заалтуудаас болоод, нууцад оруулсан заалтуудаас болоод 2020 онд 200 тэрбумын худалдан авалт хийдэг байсан өнөөдөр 23 онд 2.5 их наядын худалдан авалт хийж байгаа юм. Түүний хамгийн том жишээ нь ногоон автобусны хулгай байхгүй юу. Бид нар эрүүл мэндийнхээ асуудлыг яг ийм.../минут дуусав./

Ж.Батжаргал: Наад Ганибал гишүүний саяын ярьж байгаа асуудал бол 3 дахь асуудал байхгүй юу. Дараагийн хэлэлцэх асуудал нь. Түрүүний тэр дээр манай ажлын хэсэг тодорхой маш товчхон хариулт өгөөдөх дөө. Зүгээр ээ яах вэ, яах вэ. Ажлын хэсгийн 5.

Э.Цолмонжаргал: Ганибал гишүүний асуултад хариулъя. Туваан гишүүний асуултад хариулъя. Ганибал гишүүн тийм. Энэ малын эмийн үлдцээс сэргийлэх асуудал хуулийн төслийн 19 дүгээр зүйл дээр тусгагдсан байж байгаа. Малын эмийн үлдцийг илрүүлэх, хэмжээг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, хянах төлөвлөгөөг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална гээд байж байгаа. Энэ нь мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн хүнсний бүтээгдэхүүний эмийн үлдцийг илрүүлэх, тодорхойлох, баталгаажуулахад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргуудыг хэрэглэнэ. Олон улсын удирдамжийг баримтлан хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гээд энэ зохицуулалт нь эмийн үлдцийг тодорхойлох асуудлыг тусад нь зохицуулсан байгаа. Мөн 18 дугаар зүйл дээр бичил биетний антибиотикийн үйл үлдэгдэл буюу бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх асуудлыг мөн тусад нь зөв л болгоод тусгачихсан байж байгаа.

Ж.Батжаргал: Тодруулга байхгүй. Гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу боловсруулагдсан саналын томъёоллыг та бүгдэд танилцуулъя.

1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “8.1 дүгээр зүйлийн 12.12,” гэснийг “8.1 дүгээр зүйлийн 12.12-т заасан тусгай зөвшөөрөл” гэж өөрчилж, 17.2, 17.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.5 дахь хэсгийн “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох болон экспортлох” гэснийг хасах:

“17.2.Үйлдвэрлэх зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал

хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.”

“17.3.Импортлох зөвшөөрөл хүсэгч нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг зөвшөөрөл хүссэн өргөдлийн хамт мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ:”. Саяын энэ уншигдсан саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалт манайхан.

63.6 хувиар дэмжигдлээ.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Энхтүвшин гишүүн танилцуулах уу? Мал саяынхыг. Энхтүвшин гишүүн танилцуулна.

Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

09.42 цаг

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг үндэслэн боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ.

Байнгын хорооны гишүүд ээ,

Монгол Улсад мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд

бүтээгдэхүүний олон улсын болон дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт өвчин гарсан тохиолдолд түүний тархалтыг хязгаарлах, эрүүл малд халдвар, тархалтаас сэргийлэх арга хэмжээг яаралтай авах шаардлага үүсдэг.

Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нээлттэй болон харьцуулсан тендер шалгаруулалт гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэж гоц халдварт өвчний вакцин худалдан авахад хугацаа алдах, үүний улмаас гоц халдварт өвчний тархалт нэмэгдэх эрсдэл үүсэхээр байгаа юм.

Иймд мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд олон улсын чанарын шаардлага хангасан вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эс үгүй бол олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах зохицуулалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмж тусгах шаардлагатай байна.

Уг зохицуулалтыг хуульд нэмснээр мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд олон улсын чанарын шаардлага хангасан вакциныг хугацаа алдалгүй худалдан авах боломж бүрдэх ба үйлдвэрлэгчээс худалдан авснаар үнийн нэмэгдэл үүсэхгүй юм. Иймээс Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт

оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээсээ хүсье.

Танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу?

Туваан гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Энэ мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины асуудал чинь ер нь бас л их төвөгтэй л эд дээ. Яг амьдрал дээр наадах чинь тэгээд л ирж өгөхгүй тэгээд л баахан хөл хорио тогтоочихсон, сум орон нутаг тэр хөл хорионд нь хамаг зардал хүн хүчээ барчихсан тэгээд нэг ийм вакцин ирдэг. Тэрийг л шийдэх гэж байна гэж би ингэж харж байгаа.

Нөгөө талдаа шууд худалдан авалтаар бас тийм чанартай вакцин бас тэр болгон ирж чаддаг уу, үгүй юу. 18, 9 онд шиг санаж байна даа вакцин нь ирж өгөхгүй, ирэхээрээ хөлдөөд л, вакцин тариулсан мал нь шүлхийтээд л тэгээд яг энэ шиг ийм байдал бас нөгөө талдаа үүсчихийг үгүйсгэхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр ер нь яг ямар шалгуур тавьж авдаг юм бэ? Шууд гэрээ байгуулахад ер нь тусдаа ямар шалгуур байна? Үнэ байдаг юм уу, чанар байдаг юм уу?

Гуравт, ер нь энэ Хөдөө аж ахуйн яамныхан энэ малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, энэ вакцинжуулах, эрүүлжүүлэх асуудал дээр ямар бодлого та нар барьдаг юм бэ? Энэ Биокомбинат гээд л тэгээд л би 2 жилийн өмнө л ярьж байсан даа. Ер нь Их Хурлын гишүүн болоод л ярьж байсан. Дарга, цэргийнх нь асуудал хэвлэлээр бөөн дайн болж байдаг нэг байгууллага байгаад байдаг.

Тэгээд өнөөдөр яг хэдэн төрлийн вакцин хийгээд хангаж чадаж байгаа юм уу, үгүй юм уу? Энийг ер нь цаашаа сайжруулах хүчин чадлыг нь нэмэх ямар бололцоо байгаа юм? Тэр Унгарын

Засгийн газрын юм юу байж байгаад өнөөдөр бас хүчингүй болчихсон юм байна лээ шүү дээ. Амжилтгүй болчихсон.

Тэгэхээр ер нь ингээд бид энэ 70 сая малаа вакцинжуулах энэ их хөрөнгийг зүгээр гаднаас худалдан авалтаа хийгээд байх юм уу? Энэ Биокомбинат дээр ер нь ямар бодлого барьж байгаа юм? Одоо ер нь үйлдвэрлэж байгаа юм уу, үгүй юм уу? Үйлдвэрлэж байгаа хэдийг үйлдвэрлэж байгаа юм? Тэр талаар та бүхэн товчхон хариулаад өгөөч. Цэцэг өвчний вакцин гээд л тасарчхаад байна гээд л ингээд байгаа.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 6. Энэ анхны хэлэлцүүлэг. Ажлын хэсгийн 6 номерын микрофоныг өгөөрэй.

Б.Болдбаатар: Байна уу? Идэрбат гишүүний асуултад хариулъя. Идэрбат гишүүний асуултад хариулъя. Олон улсаас худалдаж авч байгаа вакцин дээр тавигдах шаардлага нь Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын олон улсын референс лаборатори гэж байдаг. Тухайн өвчин өвчнөөрөө. Тэр референс лабораториор баталгаажсан вакциныг л хэрэглэхийг зөвшөөрдөг юм. Тэгэхээр бид нар бол зөвхөн тийм л вакциныг шууд гэрээ байгуулж үйлдвэрлэгчээс нь худалдан авах гэсэн энэ саналыг оруулж ирж байгаа юм. Тэрнээс нээлттэйгээр худалдан авах биш.

Биокомбинат өнөөдөр архаг халдварт зооноз өвчний нийтдээ 19 нэр төрлийн вакциныг хэрэглээнд нийлүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа. Шинээр сэргэн гарч байгаа өвчнүүдийн вакцинуудын асуудлыг бол хийж чаддаггүй. Тухайлбал, бог малын мялзан, үхрийн арьс товруутах, гахайн африк мялзан, шүлхий гэх мэт өвчний вакциныг бол манайх өөрөө үйлдвэрлэдэггүй. Энийг л зөвхөн худалдан авч байгаа. Бусад вакцинуудыг бол Биокомбинат өөрөө үйлдвэрлэж, хэрэгцээнд нийлүүлж байгаа.

Ж.Батжаргал: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тийм. Энэ дээр шууд үйлдвэрлэгчээс нь худалдан авах, мөн дамжуулж худалдаж авах гэж юм байгаад байгаа юм. Заавал тэгвэл тэр үйлдвэрлэгчээс авах юм бол тэр чинь Дэлхийн мал, эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагаас ганц, хоёрхон компани биш би нэлээн байдаг болов уу гэж ингэж бодож байгаа. Манай цаг уурын онцлог бүсэд тохирсон вакцин үйлдвэрлэдэг олон байгаа байх. Дамжуулан гээд ирэхээр л тэндээс аваад л энд нэг монгол компани аваад л нааш нь дамжуулаад л ингээд л нөгөө хулгай гэдэг юм чинь гарах вий гэж. Яагаад дамжуулан гэдэг үгийг оруулж байгаа юм?

Хоёрдугаарт, тэр Биокомбинат сая үйлдвэрлэдэггүй 3, 4 вакциныг нь хэллээ. Цэцэг өвчний вакцин хийж байгаа юм уу? Тэгээд тэр нь хэзээ тарах юм бэ, хэзээ түгээх юм, хэзээ тарьж эхлэх юм бэ? Та нар энэ зүүн аймгаар, ямархуу нөхцөл байдал үүсэж байгааг мэдэж байгаа юу? Тэгээд хэзээ олгох юм тэрийг тодорхой хариулаад өгөөч.

Ж.Батжаргал: Ажлын хэсгийн 6 номер.

Б.Болдбаатар: Дамжуулан гэдэг нь бид нарт нөгөө олон улсын байгууллагаас тусламжаар өгөх болчихдог. Тэгээд олон улсын байгууллага өөрөө үйлдвэрлэгчээс нь аваад бид нарт өгөх энэ асуудлыг л зохицуулах гэж оруулсан юм. Тухайлбал, бид нар үхрийн арьс товруутах өвчин гарахад олон улсын цөмийн энергийн агентлагт хүсэлт тавьсан. Тэгэхээр тэднийх яг үйлдвэрлэгчээс нь бид нарт 500 мянган тун вакцин авч өгч байгаа юм. Тэгэхээр энийг л дамжуулан гэдгийг оруулсан юм. Гол санаа нь.

Хонины цэцэг өвчний нөхцөл байдлыг бид нар мэдэж байгаа. Сая Хэнтий аймагт голомттой газрууд нь 150 мянган тун вакцин тусламжаар

ирсэн вакцинаас хуваарилагдсан. Биокомбинатын үйлдвэрлэж байгаа вакцин энэ жил 9.5 сая тун вакцин үйлдвэрлэнэ. Эхний цуврал нь шалгалтад орчихсон байгаа. 7 сардаа багтаагаад бид нар зүүн талын 4 аймгийн бүх өвчлөмтгий хонийг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинаар вакцинжуулна.

Ж.Батжаргал: Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийг дагалдуулж оруулж ирж байгаа энэ Их Хурлын тогтоолын төсөл юм байна. Энэ дээр юу байгаа юм, бид нар энэ Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд энэ хүний эм дээр яг иймэрхүү заалт оруулсан юм. Тийм, ер нь энэ хуульд өөрчлөлт оруулаад ганц хямд үнийг биш чанарыг харгалзаж үзэх асуудлаар.

Тэгэхээр энэтэй адил заалт орж ирж байна. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань энэ чанарын асуудлыг, ялангуяа оносон, зохисон вакцины асуудлыг бас яаж сонгон шалгаруулах, яаж сонгох тал дээр хаана, ямар зохицуулалт байна? Энэ дээр хариулт авчихмаар байна. Жишээлбэл, шүлхий омгуудад янз бүрийн омгийн шүлхий гарч байна шүү дээ. Тэгэхээр энд таарсан омгийн вакциныг бид нар тэгээд л таараагүй Энэтхэгийн, Оросын гээд арай хямд хямдаас нь олж ирээд байдаг. Тэгэхээр энэ асуудал хаана ер нь зохицуулагдаж байгаа вэ гэдэг нэг асуудал.

Хоёрдугаар асуудал энэ бид нар энэ малын гоц халдварт 8 өвчин байсан. Харамсалтай нь үхрийн арьс товруу дахь нэмэгдээд ингээд 9 өвчинтэй болчихсон. Тэгэхээр энэ өвчнүүдээсээ ер нь аль болох урьдчилан сэргийлэх тал дээр нь арга хэмжээгээ илүү авахгүй бол гарсан хойно нь бид нар малын гоц халдварт өвчин салхиар л тараад явчихна. Тэгэхээр энэ үед нь маш их зардал гардаг. Тэгэхээр бид бүхэн энэ дээрээ нэлээн бодолтой

дараа дараагийн хууль, эрх зүйгээ зохицуулмаар байгаа юм.

Юу хэлэх гээд байна гэхлээр манайд орж ирж байгаа гоц халдварт шүлхий өвчин зүүн урд тал, баруун урд тал Монгол Улсын, энэ бүс нутгаас л орж ирээд байгаа. Энийг бид нар сүүлийн үед харж байгаа. Тэгэхээр бид нар энэ бүс нутгийн барер, бүс нутгийн хаалт, буферний зооно гэдэг юмаа тэр баруун урд талд, зүүн урд талдаа тавих ёстой шүү. Эндээс чинь хамаг өвчин чинь орж ирээд байгааг бүгдээрээ бид нар мэдэж байгаа.

Тэгэхээр энэ дээр дараа дараагийн хууль, эрх зүйгээ бид нар анхаарах ёстой. Ингэж байж бид нар болж өгвөл вакцингүй л эрүүл баймаар байна л даа. Энэ асуудал дээр манай улсын төсвийн энэ маш их хөрөнгө энэ вакцин дээр үрэгдээд байгаа. Тэгээд шат шаттай дамжаад явахаар вакцин тарилга, туулга гээд л ингээд л нэлээн зардлууд гарч байгаа юм.

Тэгэхээр энэ бүс нутгийн хаалтаар эрүүл болох Монгол Улсын мал аж ахуйг эрүүл болох энэ асуудлаа яримаар байгаа юм. Нэг газар шүлхий гарчихдаг жишээлбэл, Баян-Өлгийд юм уу, Дорнодод ч юм уу Хөвсгөлд гарчихдаг. Улс орноороо хаагддаг, үүнээс юу үүсэж байна гэхлээр энэнээс Монгол Улсын мал аж ахуйн малчдын бэлдэж өгсөн түүхий эдийн экспорт буюу орлого олох тал нь ингээд бүтэн хаагдчихаад байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг бид нар онцгой анхаарах ёстой.

Нэг танин мэдэхүйн чанартай нэг асуулт асуучихъя. Шүлхийгээс тайван яг ямар хугацаа өнгөрч байна? Миний багцаагаар бол жил 4, 5 сар болж байгаа байх. Энэ асуудлыг хэлээд өгчхөөч.

Ж.Батжаргал: Энэ ийм юм хөөе Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульдаа бид нэмэлт, өөрчлөлт оруулаад эрүүл бүс нутгийнхаа асуудал, хамгаалагдсан аж ахуйнхаа асуудлыг бид

тэндээ зохицуулчихсан. Одоо сая өнөө Хүний эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчлэгдэж байгаатай холбогдоод манай мал эмнэлгийн чиглэлийн эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал, эрх зүйн зохицуулалт нь орхигдчих гээд байгаа учраас энэ хуулиа бид шинэчилж гаргаж байгаа ийм зүйл. Үүгээрээ бид бас яг өнөө хүний эм, эмнэлгийн хэрэгсэл дээр тавигдаж байгаа шаардлагын дагуу ерөөсөө чанарын тухай асуудлыг онцгой анхаарах тухай асуудал нэг байгаад байгаа.

Хоёрдугаарт, үйлчилгээг нь эрүүлжүүлэлтийнх нь ажлыг технологийнх нь цаг хугацаанд хийх тухай асуудал байгаа.

Гуравдугаарт, тэр үлдэгдэл тооцох тухай асуудал байгаа. Ингэж байж энэ их зөв юм руугаа явах ёстой юм гэж. Ямар ч цагийн нөхцөл байдал үүсдэг. Малыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх ажлууд бол тэр батлагдсан төсвийнхөө хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийнхаа дагуу явна.

Онцгой нөхцөл байдал үүсээд хуримтлагдсан гэдэг юм уу, нөөцөлсөн вакцин, элдэв бусын юмнууд дутагдсан гэдэг юм уу, шинэ нөхцөл байдал үүсэх юм бол цаг алдалгүй яаралтай шийдвэрлэх үүднээс үүнийг зориуд гамшиг болон онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэж ингэж оруулж эрхийг нь нээж өгч байгаа юм. Энэнээс болж цаг хугацаа алдаж, өвчний тархалтыг нэмэхгүй байх, иргэд, малчдаа бас санхүүгийн эрсдэлд оруулахгүй байх үүднээс л энэ зохицуулалт орж байгаа гэдгийг зориуд хэлье. Ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцээд явчихъя.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу?

Ганибал гишүүнээр тасаллаа.
Ганибал гишүүн.

Н.Ганибал: Ер нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бид нар маш хянамгай байхгүй бол өнөөдөр монгол төрд байгаа авлигын хамгийн гол асуудал энэ худалдан авах дээр байдаг. Тэгээд бид нар ер нь хаашаа яваад байна вэ? Энэ үйлдвэрлэгч гэдэг энэ тодорхойлолт чинь ер нь ямар тодорхойлолт юм? Дарга үйлдвэрээ сонгоод шууд худалдаж авдаг эрхийг Мал эмнэлгийн ерөнхий газрын даргад л олгож байгаа заалтыг та бүхэн оруулж ирж байна шүү дээ. Энэ худалдан авах энэ 36 дугаар заалтад оруулах энэ нэмэлт, өөрчлөлтүүд ер нь маш том шалгуур давахгүй бол энэ байдлаараа бид нар монголын мал эмнэлгийг эрүүлжүүлнэ гэдэг энэ заалтаар эрүүлжүүлэх тухай ойлголт бүүр байхгүй болно.

Бид нар өнөөдрийн барьж байгаа, та бүхний хийж байгаа бодлууд үнэхээр надад таалагдахгүй байна бидэнд. Малчдад бүүр таалагдахгүй байна. Сая зудын ар дээр Мал эмнэлгийн ерөнхий газраас зөвлөгөө өгчхөөч. Бид нар энэ сэг зэмээ яаж устгах юм бэ гээд асуусан чинь харин өөдөөс бид нар гаднаас баахан үйлдвэр оруулж ирнэ гэнэ үү? Явуулын. Тэгээд тэр сэг зэмүүдийг бүгдийг нь тос, махаар нь ялгаад тэжээл болгохыг нь тэжээл болгоод, тос болгох нь тос болгоно гэнэ. Тийм юм яриад. Тэгээд тэр богино хугацаанд, 14 хоногийн хугацаанд тийм юм яриад мал эмнэлгийнхэн маань ингээд явж байна гэдэг өрөвдөлтэй, гунигтай ийм л нөхцөл байдал.

Тэгээд өнөөдөр бид нар Сүхбаатар аймаг дээр гэхэд 2 сая малаа

бид нар сэг зэмийг устгах ажлуудыг зохион байгуулаад өнөөдөр ер нь нийт нутгийн 50 хувь нь жоохон үнэр танартай л байгаа. Та нар тэнд оролцсонгүй. Ер нь юу хийдэг юм? Тэгээд ийм худалдан авалтын, ер нь бид нар вакцинуудыг худалдаж авахдаа Оросын Холбооны Улсаас шүлхийнийхээ вакцинуудыг авдаг. Оросын Холбооны Улс Монгол Улсаас 1 кг мах ч авдаггүй. 1 консервын жоохон мах авч байх шиг байна. Өөр бусад улс орнууд аваад байгаа тэр улс орнуудынхаа вакциныг авдаггүй.

Тэгээд хаана нь, юу нь ашигтай болоод авдаг юм. Бүүр Энэтхэгээс хүртэл нэг шүлхийний тосон суурьтай вакцин авчирсан гээд тэрнээсээ болоод бөөн хэл ам. Бид нар ер нь Энэтхэг улстай ер нь малын түүхий эд ер нь гаргадаг юм уу? Тэр экспортод гаргах гэж байгаа улс орныхоо тэр олон улсын чанар, стандартын шаардлага хангасан вакцин үйлдвэрлэгч нараас энэ юмаа аваарай даа. Одоо энэ хуулийг тэртээ тэргүй манай Ардын намынхан маань ингээд бүгдээрээ хүчээр баталчих байх. Тэгээд тэр бодлогоо ч гэсэн бас эрүүл бодлого оруулаарай. Тэр даргын хамаарал бүхий компаниуд нь Энэтхэг дистрибьютер байвал тэндээс нь оруулаад ирдэг. Тэгээд тэн дээрээ хулгай хийгдчихдэг тийм л асуудал шүү дээ.

Тэр хүний эмийн асуудал ч гэсэн яг л тийм юм руу орно. Хүн өөрөө шууд худалдаж авдаг бүх бүтээгдэхүүн дээр өнөөдөр нэг дарга үгүй байлаа гэхэд маргаашийн дарга тэрэнд дандаа л хулгай хийдэг байхгүй юу. Энэ чинь өөрөө дэлхий нийтээрээ батлагдчихсан онол байхгүй юу. Энэний эсрэг л тэр нээлттэй олон улсын тэр тендерүүдийг Монгол Улс тэрийгээ орж ирж байгаа бүтээгдэхүүн дээрээ олон улсын лавлагаа, лабораторио сайн байгуулаад, түрүүгээрээ нэг шинжилгээгээ хийгээд бидний оруулж ирсэн хүнс, бидний оруулж ирсэн эм, вакцин баталгаатай эрүүл юм байна гэдгээ нотолж чаддаг л ийм л схемийг бид нар хийх ёстой лабораторийнхоо төлөө нэг ч хүн

ярьдаггүй. Яаж тэнд худалдан авалт хийгээд дундаас нь хэдэн төгрөг олох вэ гэдэг тэр уралдаан руу өнөөдөр орчихсон юм уу даа л гэж харагдаад байна зүгээр.

Яагаад гэхээрээ үе үеийн тэр дарга нар дээр үүсдэг хамгийн том маргаан вакцин худалдаж авах. Тэрийгээ өнөөдөр тэгээд 1 бүтэлтэй тараагаад ингээд малаа эрүүлжүүлэх энэ асуудлаа ч, бас схемээ ч, төлөвлөгөөгөө ч биелүүлж чадахгүй ингээд л яваад байгаа юм.

Ж.Батжаргал: Үгүй хэдүүлээ бас жоохон ялгаж ойлгомоор байна. Мал эрүүлжүүлэх вакцин, био бэлдмэл, тарилга, туулгалт, хэрэгслүүд бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулиараа явна. Яах аргагүй гамшигийн болон ийм онцгой нөхцөл байдал үүсчихлээр энэ өвчин нь гараад, байж байгаа нөөцлөгдсөн вакцин чинь дутсан гэдэг юм уу ийм тохиолдолд бид цаг алдахгүй шуурхай авах үүднээс шууд үйлдвэрлэгчээс нь буюу тэр олон улсын байгууллагаас нь авах нөхцөлийг л хангаж байгаа. Энэ Хүний эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд яагаад энэ заалтыг оруулсан бэ гэхээр зэрэг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын төрөлжссөн байгууллагууд дэлхийн хэмжээнд захиалга өгөөд тендерээ зарлачихдаг. Өнөө том худалдан авалт учраас үнэ нь доошоо буучихдаг.

Тийм учраас яг тэр үнээр нь татаж авах бололцоо нь бүрдэх юм гэж үзэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулсан байхгүй юу. Үндсэндээ яг тэр санааг энэ хуулиар нээж өгсөн юм бол гэдгийг би зориуд хэлмээр байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт, саналтай гишүүн байна уу?

Алга байна гишүүдээс.

Гишүүдээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна. Санал хураалт.

3 дугаар зүйл байхгүй. Энэ манайхан юун дээр юу яасан юм билээ. Санал хураалт.

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Идэрбат гишүүн танилцуулна.

Асуудлыг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орёе.

“Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оруулаарай.

Хууль санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ танилцуулна.

Төсөл өргөн баригч орж ирээгүй байгаа тул чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.2 дахь Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Ерөнхий сайд, эс үгүй бол асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тухайн Засгийн газрын гишүүн түр эзгүй байгаа бол түүнийг орлож байгаа Засгийн газрын гишүүн танилцуулна гэсэн ийм заалттай. Сайд байхгүй тул энэ асуудлыг хойшлууллаа.

*Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх
асуудал дууслаа.*

*Ажлын хэсгийн гишүүд, Байнгын
хорооныхоо гишүүдэд баярлалаа.*

10.02 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР*